# ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

facebook.com/Rtcc.m0n
http://rtcc.mrtd.gov.mn
info@rtcc.mrtd.gov.mn
+976 77244409

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

2019 оны 04-р сарын дугаар

## Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд дугаар олголт хийж, мэдээллийн нэгдсэн санд бүртгэж байна.

“Төмөр замын зураг төслийн институт” ХХК-ийн 1 ачааны хагас вагон, “МАК ЦЕМЕНТ” ХХК-ийн 19-7075 загварын цементийн 50 хоппер вагонд бүртгэлийн дугаар олгосон.

4-р сард нийт 130 вагоны мэдээллийг хөдлөх бүрэлдэхүүн бүртгэлийн программд бүртгэн оруулж, хөдлөх бүрэлдэхүүний бүртгэлийн мэдээллийн сан болон түүний үйл ажиллагааны талаарх тайланг ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-т хүргүүлсэн.











| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | 3973 | 560052 | хагас | EC70A | 24 | 4 | 23.5 | 1-BM | 70 | 88 |
| 7 | 4081 | 561068 | хагас | EC70A | 24 | 4 | 23.5 | 1-BM | 70 | 88 |
| 8 | 376 | 560060 | хагас | EC70A | 24 | 4 | 23.5 | 1-BM | 70 | 88 |
| 9 | 4083 | 561076 | хагас | EC70A | 24 | 4 | 23.5 | 1-BM | 70 | 88 |
| 10 | 3977 | 560078 | хагас | EC70A | 24 | 4 | 23.5 | 1-BM | 70 | 88 |
| 11 | 4060 | 560086 | хагас | EC70A | 24 | 4 | 23.5 | 1-BM | 70 | 88 |
| 12 | 4079 | 561084 | хагас | EC70A | 24 | 4 | 23.5 | 1-BM | 70 | 88 |
| 13 | 4046 | 560094 | хагас | EC70A | 24 | 4 | 23.5 | 1-BM | 70 | 88 |
| 14 | 4082 | 561092 | хагас | EC70A | 24 | 4 | 23.5 | 1-BM | 70 | 88 |
| 15 | 3978 | 560102 | хагас | EC70A | 24 | 4 | 23.5 | 1-BM | 70 | 88 |
| 16 | 3979 | 560110 | хагас | EC70A | 24 | 4 | 23.5 | 1-BM | 70 | 88 |
| 17 | 4090 | 561100 | хагас | EC70A | 24 | 4 | 23.5 | 1-BM | 70 | 88 |
| 18 | 3980 | 560128 | хагас | EC70A | 24 | 4 | 23.5 | 1-BM | 70 | 88 |

## “УБТЗ“ ХНН -ийн “Нөөц, инноваци, хөгжил” сэдэвт шинэ бүтээл ашигтай загварын үзэсгэлэнд оролцлоо.

“УБТЗ“ ХНН-ээс 2019 оны 04 сарын 25-ны өдөр зохион байгуулсан “Нөөц, инноваци, хөгжил” сэдэвт үзэсгэлэнд төвийн мэргэжилтнүүд оролцож суурь бүтцийн ШБАЗ-ын талаар мэдээлэл авч танилцуулга материалыг төвийн сургалтын танхимд байршууллаа.







## Стандартын төсөлд мэргэжлийн байгуулагуудаас санал аван ажиллалаа.

“Ачааны чингэлэг - кодчилол, тодорхойлолт, тэмдэглэгээ” ISO-6346-2019 стандартыг орчуулан боловсруулах, батлуулах ажлын хүрээнд ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-ын албан бичгээр ирүүлсэн саналыг тусган чингэлгийн жингийн тэмдэглэгээг олон улсын “Си” системд шилжүүлэн засварлаж, Төмөр зам, далай ашиглалт ба усан замын тээврийн стандартчиллын техникийн хороогоор хэлэлцүүлэхээр Стандартчилал, хэмжил зүйн газарт албан бичгээр хүргүүлсэн.










## Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийж байна.

Нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд хяналт тавих чиг үүргийн хүрээнд “УБТЗ“ ХНН-ээс авсан 2019 оны 3, 4-р сарын тасалдлын мэдээг нэгтгэн тайлан гарган ажиллаж байна.

Мөн Галт тэрэгний хөдөлгөөний 2019 оны зуны нэгдсэн зурмагийн төслийг “МТЗ” ТӨХК, “УБТЗ” ХНН-ээс албан бичгээр хүлээн авч боловсруулан холбогдох албан тушаалтнуудад танилцуулсан.

## “Цацраг идэвхит материалыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны дүрэм“ төсөлд саналаа хүргүүллээ.

Зам, тээврийн хөгжлийн яамнаас ГТХЗНТ-д ирүүлсэн албан бичгийн дагуу “Цацраг идэвхит материалыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн төсөлд санал боловсруулж албан бичгээр хариу хүргүүлсэн.





## Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээний нэгдсэн санг бүрдүүлэн ажиллаж байна

Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг хэрэгжүүлж төмөр замын салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.

Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 01/92 дугаар тушаалаар батлагдсан улсын тайлан Т-9 маягтын дагуу төмөр замын тээврийн тээвэрлэлтийн мэдээг Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогыг хэрэгжүүлэх газар, Бодлого төлөвлөлтийн газарт хүргэж танилцуулсан.



2019 оны 4 дүгээр сарын статистик мэдээ, мэдээллийг нэгтгэж нийгэм, эдийн засгийн байдалд нөлөөлсөн байдлаар буюу төмөр замын ачаа болон зорчигч тээвэрлэлт, ачаа ачилт, зорчигч болон ачаа эргэлт, дамжин өнгөрсөн болон тээвэрлэсэн ачаа, галт тэрэгний зурмагийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, ЗТХЯ-ны www.mrtd.gov.mn, төвийн www.rtcc.mrtd.gov.mn цахим хуудаст инфографик хэлбэрээр байршуулж олон нийтэд нээлттэй, ил тод мэдээллээ.

## Төмөр замын холбогдолтой гадаад улсын сэтгүүлийн 04-р сарын дугаарыг төвийн цахим хуудсанд байршууллаа

Гадаад орнуудын төмөр замын салбартай холбоотой "Railway Magazine", "Trains", "Modern Railways" сэтгүүлийн 04-р сарын дугаарыг харах болон татаж авах форматад хөрвүүлэн төвийн www.rtcc.mrtd.gov.mn цахим хуудсанд байршуулж, олон нийтэд хүргэлээ.









## Төвийн мэргэжилтнүүд ХАБЭА болон эрхзүйн сургалтуудад хамрагдлаа.

“ГТХЗНТ” УТҮГ-ын мэргэжилтнүүд дараах сургалтуудад хамрагдан мэдлэг мэдлэгээ дээшлүүллээ. Үүнд:
“Осол гэмтлийн үед анхны тусламж үзүүлэх тухай”
“Жендэрийн тухай ойлголт, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг сурталчлах нь”
“Захиргааны ерөнхий хуулийг сурталчлах нь: Захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны гэрээний тухай ойлголт”
“Төмөр замын тээвэрлэлт эрх зүйн зохицуулалт”
“Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ”
“Төмөр замын салбар дахь терроризмын тухай ойлголт, урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтуудад тус тус хамрагдсан.




















## "Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв" УТҮГ-ын санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүн, гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийгдэв.

Зам тээврийн хөгжлийн сайдын "Хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулах тухай" 105 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг "Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв" УТҮГ-ын санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүн, бодлого, хөтөлбөр, норм, дүрэм журам, гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн. Үүнд:

- 2016-2018 онд Төрийн захиргааны байгууллагаас төвд өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилтийн тайлан

- Ажлын байрны дагуу 2016-2018 онд хөдлөх бүрэлдэхүүнтэй холбоотой хийгдсэн судалгаа, дүрэм, журам, заавар, стандарт, норм, нормативын чиглэлээр хийгдсэн ажил болон түүнтэй холбоотойгоор харъяа байгууллагуудад явуулсан албан бичгийн жагсаалт

- Төвөөс 2016-2018 онд боловсруулан хэрэгжүүлсэн стандартын орчуулгын нэгтгэл

- Хөдлөх бүрэлдэхүүний бүртгэлийн программ хангамжийн мэдээллийн сан болон түүний үйл ажиллагааны талаарх тайлан

Ажлын байрны дагуу 2016-2018 онд хөдлөх бүрэлдэхүүнтэй холбоотой хийгдсэн судалгаа, дүрэм, журам, заавар, стандарт, норм, нормативын чиглэлээр хийгдсэн ажил болон түүнтэй холбоотойгоор харъяа байгууллагад явуулсан албан бичгийн жагсаалтыг ЗТХЯ-ны хөдлөх бүрэлдэхүүн хариуцсан ахлах мэргэжилтэнд гаргаж өгсөн.





ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ

2019 оны 4 дүгээр сард өссөн дүнгээр зорчигч тээвэрлэлт 763.9 мян.зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 7.2%-иар буурсан, ачаа тээвэрлэлт нь 8715.4 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 7.2%-иар өссөн үзүүлэлттэй байна.

# ИНФОГРАФИК

## Зорчигч тээвэрлэлт /мян.зор/
/өссөн дүнгээр/

| | 2018он | 2019он |
|---|---|---|
| Олон улс | 22.8 | 25.2 |
| Орон нутаг | 800.0 | 738.7 |

## Зорчигч эргэлт /сая.зор-км/

| 2018он | 2019он |
|---|---|
| 303.6 | 289.0 |

## Дамжин өнгөрсөн ачаа /мян.тн/
/өссөн дүнгээр/




2018 /1-4 сар/ 1074.5 мян.тн < 2019 /1-4 сар/ 1188.3 мян.тн

## Ачаа ачилт /өссөн дүнгээр/

6169.0 мянган тонн

6675.4 мянган тонн

| | | Нүүрс хангалт, нөөцлөлтийн мэдээ | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ТЭЦ-2 | ТЭЦ-3 | ТЭЦ-4 | Дархан | Эрдэнэт | Амгалан |
| Нөөц | Тонн | 7168 | 47332 | 129341 | 36428 | 26558.1 | 0 |
| | Хоног | 10 | 16 | 16 | 40 | 16 | 0 |
| Өвлийн ачааллын нөөц | Хоног | 8 | 9 | 9 | 20 | 17 | 0 |
| Хоногийн зарцуулалт | Тонн | 651 | 2824 | 8040 | 910 | 0 | 0 |
| Ажиллаж байгаа зуухны тоо | | 2 | 5 | 5 | 2 | 0 | 0 |

## Тээвэрлэсэн ачааны мэдээ
8715.4 /мян.тн/
/өссөн дүнгээр/

| | 2018 | 2019 |
|---|---|---|
| Экспорт | 2903.7 | 3145.5 |
| Импорт | 883.2 | 851.7 |
| Дамжин өнгөрөх | 1074.5 | 1188.3 |
| Орон нутаг | 3265.3 | 3529.8 |

2019 /4 сар/ - 6675.4 мян.тн

| 45.6% | 34.2% | 20.2% |
|---|---|---|
| Нүүрс | Төмрийн хүдэр | Бусад төрөл ачаа |

## Галт тэрэгний зурмагийн биелэлт
/өссөн дүнгээр/

| Суудал г/т 2018 | Суудал г/т 2019 | | Ачааны г/т 2018 | Ачааны г/т 2019 |
|---|---|---|---|---|
| 2366 | 2100 | Өнгөрүүлэлт | 12170 | 14594 |
| 2567 | 2389 | Явуулалт | 13370 | 18316 |

Зорчигчийн галт тэрэг явуулалтаар 2405 г/т төлөвлөснөөс 2389 г/т явуулж биелэлт 99.3%, өнгөрүүлэлтээр 2146 г/т төлөвлөснөөс 2100 г/т өнгөрүүлж биелэлт 97.9%, ачааны галт тэрэг явуулалтаар 18402 г/т төлөвлөснөөс 18316 г/т явуулж биелэлт 99.5%, өнгөрүүлэлтээр 14946 г/т төлөвлөснөөс 14594 г/т өнгөрүүлж биелэлт 97.6% болж ерөнхий дүнгээр зурмагийн биелэлт 98.6% байна.

# СТАТИСТИК

/2019 оны 4 дүгээр сарын байдлаар/

## Төмөр замын тээврийн үндсэн үзүүлэлт




Зорчигч тээвэрлэлт 2019 оны дөрөвдүгээр сард 201.3 мян.зорчигч тээвэрлэсэн, ачаа тээвэрлэлт нь энэ сарын байдлаар 2133.3 мян.тн ачаа тээвэрлэсэн байна.

## Дамжин өнгөрсөн ачаа /мян.тн/




Дамжин өнгөрсөн ачаа 2019 оны дөрөвдүгээр сард 349.0 мян.тн тээвэрлэсэн байна.

## Ачилт- ачааны төрлөөр

/2019 оны 4 дүгээр сард/




Ачилтаар 2019 оны дөрөвдүгээр сард нүүрс, төмрийн хүдэр, барилгын материал, зэс, молибдений баяжмал, нефтийн бүтээгдэхүүн, жонш өссөн үзүүлэлттэй байна. Нийт 1567.5 мян.тн ачсан байна.



**8-р давхар, Хан-Уул цамхаг,**
**Б.Шаравын гудамж 6,**
**3-р хороо, Хан-Уул дүүрэг,**
**Улаанбаатар хот 17042, Монгол Улс**